

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт.....	1
1.Аудитын гэрчилгээ	2
2.Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Менежментийн захидал	12
4.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	15
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	17
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	19
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	21
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	22
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	24
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	25

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
БНАСУ	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад ард улс
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Д.ДАВААСҮРЭН ТАНАА

20 20. 02. 21 № 06/590
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гадаад харилцааны яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гадаад харилцааны яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гадаад харилцааны яамны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудитын тайлан

2.1. Оршил

Гадаад харилцааны яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллах, төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв тайлагнах, зардлыг бодитой төсөвлөх, төсвийг үр ашигтай зарцуулах, хөрөнгийн шинжтэй зүйлсийг зардалд шууд тусгахгүй байх, авлага, өглөгийг барагдуулах, тооцоо нийлж баталгаажуулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гадаад харилцааны яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаад харилцааны яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 27-ноос 2020 оны 2 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Чанцалдулам хариуцаж хэрэгжүүлэв.

Гадаад харилцааны яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 08/468 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Гадаад харилцааны яам нь “Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд олон улсын таатай гадаад орчныг бүрдүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажилладаг байна.

Дээрх эрхэм зорилгыг биелүүлэхдээ “Монгол Улсын гадаад харилцааг үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон зарчим, чиглэлээр улс орны болон дэлхий дахины улс төр, эдийн засгийн шинэ нөхцөл байдалтай уялдуулан тууштай хэрэгжүүлж, үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг идэвхтэй явуулах, гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг эрхэмлэж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр суурийг бэхжүүлэх, гадаад эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тууштай явуулах зорилтуудыг удирдлага болгоно” гэж үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл нь:

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах таатай гадаад орчныг бүрдүүлэх;
- Монгол Улсын хөгжлийг хангах таатай гадаад орчныг бүрдүүлэх;
- Монгол Улсын иргэдийн эрх ашиг, бизнесийн ашиг сонирхлыг хилийн чанадад хамгаалах зэрэг болно.

Гадаад харилцааны яамны санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Засгийн газрын 2016 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” 3 дугаар тогтоолоор Гадаад харилцааны яамны бүтэц, орон тооны хязгаарыг 142 байхаар баталсныг Засгийн газрын 2019 оны 65 дугаар тогтоолоор 147 болгосон байна.

Гадаад харилцааны яам нь 2019 оны жилийн эцсийн байдлаар улс төрийн албан тушаалтан 2, төрийн тусгай албан хаагч /дипломат ажилтан/ 111, төрийн захиргааны албан хаагч 15, төрийн үйлчилгээний албан хаагч 12, гэрээт ажилтан 3, нийт 143 хүн ажиллаж байна.

Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн яамны 2019 оны 74 дүгээр тушаалаар “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны хэмнэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих” журам
- Нийгмийн даатгалын тухай хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн;
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр “Жишиг норм батлах тухай” тушаал

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Гадаад харилцааны яам нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ГҮҮК СОФТ ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн “Axplorer 3.16” программ хангамж ашигладаг байна.

Гадаад харилцааны яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө хөтөлбөр боловсруулан батлуулж ажилласан боловч яамны санхүүгийн үйл ажиллагаанд тавьсан дотоод хяналт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд давтан илэрч байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Гадаад харилцааны яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 5,185,249.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 51,852.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 130,123.3 мянган төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаарх суурь үзүүлэлт буюу санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 13,012,326.7 мянган төгрөгөөс 1 хувиар тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Гадаад харилцааны яамны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 228,884.8 мянган төгрөгөөр буюу 20.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	4,306.2	11,039.2	6,733.0
Авлага	327,936.6	332,037.5	4,100.9
Урьдчилгаа	32,966.0	82,266.2	49,300.2
Бараа материал	187,553.1	148,986.1	(38,567.0)
Үндсэн хөрөнгө	10,666,124.3	10,873,441.9	207,317.6
Нийт хөрөнгө	11,218,886.2	11,447,771.0	228,884.8
Өр төлбөр	186,806.9	112,133.5	(74,673.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	11,032,079.3	11,335,637.5	303,558.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,218,886.2	11,447,771.0	228,884.8

Авлага дансны үлдэгдэл өссөн нь татаас санхүүжилтийн авлага 5,030.7 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ. Тайлант оны эцэст 139,126.3 мянган төгрөгийн тооцоо нийлсэн актгүй авлага тайлагнагдсаны 98.2 хувь буюу 136,607.9 мянган төгрөг нь 2010-2014 онд үүссэн дараа тайлангийн томилолт, цалингийн тооцоотой холбоотой үүссэн тодорхойгүй, эрсдэлтэй авлагын үлдэгдэл байна.

Урьдчилж гарсан зардлын дансны үлдэгдлийн 61.9 хувь буюу 50,956.2 мянган төгрөг нь 2020 оны 1 дүгээр сарын 14-31-ний өдрүүдэд хийгдэх ерөнхийлөгчийн айлчлалын бүрэлдэхүүний томилолтын урьдчилгаа, мөн 24,660.0 мянган төгрөг нь “галт хан” мэдээллийн аюулгүй байдлын программын лицензийн 2 жилийн урьдчилгаа төлбөр байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь тусгай зориулалтын материал буюу е-паспорт, цахим болон энгийн паспортын үлдэгдэл буурснаас шалтгаалжээ. Тайлант онд 150,450.2 мянган төгрөгийн худалдан авалт хийснээр 33,966.7 мянган төгрөгийн бараа материалын нөөц нэмж үүсгэсэн байна.

Үүнээс 3,453.5 мянган төгрөгийн барилгын засварын материал, 747.0 мянган төгрөгийн визитийн материал, 19,578.1 мянган төгрөгийн ашиглалтад байгаа хангамжийн материал, 5,570.0 мянган төгрөгийн 89 ш принтерийн хор, 3,619.2 мянган төгрөгийн 377 боодол бичгийн цаас, 4,500.0 мянган төгрөгийн Ойр дайдын оронтой түншилсэн түүхээс ном 300 ширхэг, 1,101.1 мянган төгрөгийн МУ-ын гадаад бодлогын хөх ном 130 ширхэг, 5,000.0 мянган төгрөгийн бэлэг дурсгал зэрэг бараа материалын нөөц байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 207,317.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд нийт 198,230.0 мянган төгрөгийн худалдан авалтыг төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос худалдан бэлтгэсэнтэй холбоотой байна.

Мөн хөрөнгө оруулалтаар 63,569.7 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 420 дугаар тогтоолоор 884,071.1 мянган төгрөгийн хөрөнгийг Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨҮГ-аас үнэ төлбөргүй хүлээн авч, түүх соёлын дурсгалт зүйлд 26,316.0 мянган төгрөгийн уран зургийг урьдчилж гарсан зардлаас хөрөнгөөр бүртгэснээс холбоотой нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс тайлант онд ТӨБЗГ-ын 2019 оны А/1/4155 тоот албан бичгээр 116,770.9 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг БНАСУ-д суугаа элчин сайдын яаманд үнэ төлбөргүй шилжүүлсэн, ТӨБЗГ-ын 2018 оны А/5/4890 тоот албан бичгээр 404,998.5 мянган төгрөгийн хөрөнгийг актлах шийдвэрээр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 74,673.4 мянган төгрөгөөр буурсан гол шалтгаан нь байгууллагад төлөх өглөг 93,125.4 мянган төгрөгөөр буурсан боловч хувь хүний орлогын албан татварын өглөг 15,096.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн, өмнөх онуудад үүссэн цалингаас суутган тооцсон өглөгийн үлдэгдэл байна.

Гадаад харилцааны яам нь өмнөх оноос өр төлбөрийн дүнг 74,673.4 мянган төгрөгөөр барагдуулж ажилласан боловч 2019 оны санхүүгийн тайланд дахь нийт өглөгийн үлдэгдлийн 66.1 хувь буюу 74,153.4 мянган төгрөг нь тайлант хугацаанд шинээр нэмэгдсэн, үүнээс 45,585.1 мянган төгрөг нь шатахууны өглөг байна.

Мөн 31,670.2 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүйгээс 24,976.7 мянган төгрөгийн өглөг нь 6 жилийн өмнө үүссэн тодорхойгүй өр төлбөр байгаа нь тайлангийн үлдэгдлийг өсгөж байгаа тул анхаарал хандуулан барагдуулах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 11,310,977.5 мянган төгрөг болж 303,558.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 11,205,001.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас, 9,820,001.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 560,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 825,000.0 мянган төгрөгийн Олон Улсын хамтын ажиллагааны санг өөрийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гадаад харилцааны яам тайлант онд 560,000.0 мянган төгрөгийн төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлого олж санхүүжихээр батлагдсанаас гүйцэтгэлээр 2,350,335.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 4.2 дахин биелүүлсэн байна. Туслах үйл ажиллагааны орлого 1,790,335.3 мянган төгрөгөөр давсан нь Монгол улсад нэвтрэх гадаад иргэдийн паспортод наах визийн хуудсыг үйлчилгээний хөлсний хамт 3 ам.доллар болгосон, дипломат болон албан паспортын төлбөртэй тус тус холбоотой байна.

Тайлант онд төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоос 1,140,292.2 мянган төгрөгийг улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны давсан орлого, төсвийн зарлагын хэмнэлтийг зарцуулах тухай Сангийн сайдын 2019 оны 251 дүгээр тушаалаар эрх нээлгэн зарцуулжээ.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 1,790,335.3 мянган төгрөгөөр давж биелсэн нь 2019 оны үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг үндэслэл муутай хэт багаар баталсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,980,037.2 мянган төгрөг буюу 62.3 хувьтай байгаа нь Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх 825,000.0 мянган төгрөгийн хөтөлбөрийг Засгийн газрын 2019 оны 87 дугаар тогтоолоор татан буулгасан, мэдээлэл технологийн үйлчилгээг сайжруулах зориулалтаар батлагдсан 990,000.0 мянган төгрөгийг зарцуулаагүй, мөн Засгийн газрын гадаад шилжүүлгийн зардалд 2,887,703.1 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 62.3 хувь буюу 1,798,396.1 мянган төгрөгийг зарцуулсан зэргээс шалтгаалжээ.

Засгийн газрын гадаад шилжүүлгийн зардалтай холбоотой өр төлбөр тайлагнагдаагүй бөгөөд энэ нь 2019 оны Засгийн газрын гадаад шилжүүлгийн зардлын төлөвлөгөөг үндэслэл муутай хэт өндрөөр баталсан байна.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар БНХАУ-аас тус яамны ажиллах нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлж олгосон 192,246.3 мянга, Засгийн газрын нөөц хөрөнгөөс 778,817.5 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 128,666.4 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,413,660.4 мянга, урьд оны үлдэгдлээс

санхүүжих нэмэлт орлого 20,075.5 мянга, төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан засгийн газар хоорондын гэрээ болон олон улсын байгууллагаас авах хөнгөлөлт 222,973.8 мянга, нийт 2,756,439.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Мянганы сорилын корпорацид 221,973.8 мянга, Засгийн газрын тогтоолын дагуу 778,817.5 мянга, үйл ажиллагаанд 1,306,051.7 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 445,125.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, нэмэлт санхүүжилтийн касст 4,471.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн 445,125.3 мянган төгрөгөөс 192,246.2 мянган төгрөгийг Сангийн яамнаас авах санхүүжилтийн авлагаар тооцоо нийлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 179,235.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 60,889.4 мянган төгрөгийн залруулж, 20,487.0 мянган төгрөгийн 4 зөрчилд 1 акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлж, 97,858.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө. Үүнд:

1. ГХЯ нь 2019 оны жилийн эцэст Fortinet компанийн FortiGate-101E Next Generation Firewall 3 жилийн лицензийн төлбөрт нийт 24,660.0 мянган төгрөгийг урьдчилж шилжүүлж, зардалд шууд бүртгэсэн нь тухайн жилийн батлагдсан төсөв, байгууллагын ажил гүйлгээ буюу үйл явдал тайлант хугацаанд зөв дүнгээр бүртгэгдсэн орлого, зардлыг зөв хуваарилсан байх гэсэн батламж мэдэгдэлтэй тус бүр нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланг залруулсан.

2. Долларын кассаас 2019 оны эхний 9 сард их хэмжээний бэлэн гүйлгээний зарцуулалт гаргаснаас ГХЯ-ны тайлант жилийн батлагдсан төсөвт зардал нийт 36,229.4 мянган төгрөгөөр хэтэрснийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос урсгал харилцах руу шилжүүлэн орлогоор бүртгэж, хэтэрсэн зардлын дүнгээр зардал бууруулан бичиж, төсвийн гүйцэтгэлийн тайланг буруу тайлагнасан нь Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаал, 2012 оны 76 дугаар тушаалын холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланг залруулсан.

3. Батлагдсан төсөвт зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулахдаа 6,600.0 мянган төгрөгийн газрын төлбөрийг бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулсан нь Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалын хавсралт тайлбарын 210807, 2109 гэсэн зардлын ангиллын заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4. ГХЯ-ны нийт өглөгийн үлдэгдлийн 55.2 хувь буюу 58,588.5 мянган төгрөг нь Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨҮГ-т төлөх шатахууны өглөг бөгөөд үүнээс 45,585.1 мянган төгрөг нь тайлант хугацаанд шинээр нэмэгдсэн байна. Тайлант онд тайлагнагдсан шатахууны зарцуулалтыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан жишиг нормоор тооцоход автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтнууд нийт 6,127.9 мянган төгрөгийн шатахууны зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

5. Касст байгаа бэлэн мөнгөний үлдэгдлийг тоолж, тооцоог бодоход 18,871.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 6,759.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 6.1-д "Төсвийн байгууллагын кассад хэрэгцээнээс илүү мөнгө хадгалах явдлаас зайлсхийх үүднээс жижиг мөнгөн сангийн хэмжээг нарийвчлан төлөвлөж байна", 6.2-т "Төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээ нь тухайн төсвийн байгууллагын жилийн батлагдсан төсвөөс хамааран хамгийн ихдээ 1.500.0-3.000.0 мянган төгрөгийн хэмжээтэй байна", Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т: "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

6. Гадаад харилцааны сайдын Бүгд найрамдах Словак улсын Братислав хотноо болсон Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагуудын сайд нарын 26 дугаар уулзалтад оролцох томилолтын дараа тайланг журмын дагуу хаагаагүйгээс 1,000.0 төгрөгийн томилолтын буцаалт үүсгэж тайлант оны үр дүнг бууруулсан нь байгууллагын ажил гүйлгээ буюу үйл явдал тайлант хугацаанд зөв дүнгээр бүртгэгдсэн орлого, зардлыг зөв хуваарилсан байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

7. ГХЯ-ны "Ёслол хүндэтгэлийн өргөө"-ний барилга угсралтын ажил дуусаж 2017 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан боловч улсын комиссын акт гараагүйгээс санхүүгийн тайлангийн дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй 2 жил гаруй үхмэл хөрөнгийн шинжтэй байна. Өмнөх оны аудитаар ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэнд тус барилгын улсын комиссын актыг гаргуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгсөн боловч хэрэгжээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитаар илэрсэн 97,858.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн тайланд авлагын үлдэгдэлд 136,607.9 мянган төгрөгийн 2010-2014 онд үүссэн дараа тайлангийн томилолт, цалингийн тооцоотой холбоотой болон тодорхойгүй, эрсдэлтэй авлага байгаад анхаарал хандуулан барагдуулах арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Гадаад харилцааны яамны Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 136 мэдээллийг хугацаанд нь, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 3 мэдээллийг байршуулаагүй бөгөөд цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй нийт 134 ширхэг 4,396,840.1 мянган төгрөгийн ажил гүйлгээг мэдээлжээ.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 330.4 мянган төгрөгийн зөрчилд тогтоосон актыг бүрэн барагдуулсан, 105,700.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 66.7 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гадаад харилцааны яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Аудитаар залруулагдаагүй 118,345.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 130,123.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өгч байна.

Гадаад харилцааны яамны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

ГХЯ нь 1,045.3 мянган төгрөгийн үнэ бүхий принтер, кофе чанагчийг худалдан авахдаа үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй, мөн 2,204.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг тооцооны дансаар дамжуулалгүй зардлаар шууд тайлагнаж, тайлант үеийн үр дүнг бууруулсан нь УСНББОУС 17, УСНББОУС-12 болон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.33 дах заалт, 4.15-д "Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс ..." гэж заасантай тус бүр нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй, бүртгэлээр тавих хяналт сул байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, нярвыг арга зүйгээр хангах, хөрөнгийн шинжтэй зүйлсийг шууд зардалд тусгахгүй байх;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 Зардалтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Гадаад томилолтоор явахдаа гадаад зочинд 100.0-640.0 мянган төгрөгийн бэлэг, дурсгалын зүйл гардуулж, нийт 20,456.0 мянган төгрөгийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах",

ЗГ-ын 1999 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан "Бэлэг дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам"-ын 2.3 дах заалтуудтай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Төсвийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох журамтай нийцүүлэн дотооддоо журам боловсруулан хянуулж, мөрдөн ажиллах;

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.3 Өр төлбөртэй холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

ГХЯ нь өмнөх оноос өр төлбөрийн дүнг 74,673.4 мянган төгрөгөөр барагдуулж ажилласан боловч 2019 оны санхүүгийн тайланд дахь нийт өглөгийн үлдэгдлийн 66.1 хувь буюу 74,153.4 мянган төгрөг нь тайлант хугацаанд шинээр нэмэгдсэн, үүнээс 45,585.1 мянган төгрөгийн шатахууны өглөг байна. Мөн 31,670.2 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүйгээс 24,976.7 мянган төгрөгийн өглөг нь 6 жилийн өмнө үүссэн тодорхойгүй өр төлбөр байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д: эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэнтэй тус бүр нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй, бүртгэлээр тавих хяналт сул байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавьж, өр төлбөр үүсгэхгүй ажиллах;

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

3.4.1. Илрүүлэлт:

Гадаад харилцааны яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг нь 2013 онд боловсруулагдсан бөгөөд 2013 оноос хойш өөрчлөгдсөн хууль тогтоомж, Сангийн сайдын баталсан болон бусад батлагдсан заавар журмын өөрчлөлтийг тусгаагүй байна. Энэ нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

3.4.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандартын шаардлага хангаагүй байх

3.4.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын онцлогийг тусгаж, шинэчлэн боловсруулах;

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.5 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

3.5.1. Илрүүлэлт:

Долларын кассын тайланд бэлнээр тушаасан визний орлогыг ажлын дараагийн өдөрт багтаан тушаахгүйгээр нийт 108,675.3 мянган төгрөгийн гадаад томилолт болон бусад зардлыг бэлнээр зарцуулж байгаа нь батлагдсан төсөвт зардал хэтрэх эрсдэлтэй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 2 дугаар зүйлийн 2.6-д: Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана, мөн 2.5-д “Төсвийн байгууллага бэлэн мөнгөөр болон арилжааны банкны төлбөрийн картаар зарлага хийхдээ зарцуулалтын эрхийн хүрээнд зөвшөөрөгдсөн төсвийн хуваарийн дагуу гүйцэтгэх бөгөөд Төрийн сангаас тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн баталж өгсөн жижиг мөнгөн сангийн /цаашид “ЖМС” гэх/ хязгаарыг дагаж мөрдөнө” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.5.2. Эрсдэл:

Кассын үлдэгдлийг тооллого хийгээгүй, тооллогын баримт зөрүүтэй байх, касст их хэмжээний мөнгөний гүйлгээ хийгддэг байх

3.5.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах;

3.5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	552,761,923.40	574,329,186.13
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,306,191.00	11,039,238.45
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	6,759,146.80
31110	Төгрөг	-	2,287,576.80
31120	Гадаад валют	-	-
31130	Нэмэлт санхүүжилт	-	4,471,570.00
31140	Касс арилжааны банк	-	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,247,191.00	4,280,091.65
31210	Төгрөг	4,247,191.00	4,280,091.65
31211	Төрийн сангийн харилцах	4,237,191.00	4,237,191.00
31213	Арилжааны банк дахь харилцах	10,000.00	42,900.65
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	59,000.00	-
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	327,936,645.75	332,037,535.73
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	664,923.47
33300	Татаас, санхүүжилтийн авлага	187,215,647.69	192,246,283.18
33500	Бусад авлага	140,720,998.06	139,126,329.08
33510	Байгууллагаас авах авлага	100,203,056.33	98,651,587.35
33520	Хувь хүмүүсээс авах авлага	40,517,941.73	40,474,741.73
34	УРЬДЧИЛГАА	32,966,000.00	82,266,268.34
34600	Урьдчилж гарсан зардал	32,966,000.00	82,266,268.34
35	БАРАА МАТЕРИАЛ	187,553,086.65	148,986,143.61
35100	Түүхий эд материал	140,804,743.74	68,271,047.80
35110	Тусгай зориулалттай материал	140,804,743.74	68,271,047.80
35400	Хангамжийн материал	46,748,342.91	80,715,095.81
35410	Бичиг хэргийн материал	2,398,174.00	16,845,660.00
35450	Барилгын засварын материал	-	3,453,503.90
35460	Хүнсний материал	-	747,039.00
35470	Бусад хангамжийн материал	44,350,168.91	59,668,892.91
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,666,124,328.31	10,873,441,899.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,666,124,328.31	10,873,441,899.10
39200	Биет хөрөнгө	9,594,404,125.98	9,820,054,296.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,541,738,992.55	2,610,008,368.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	-72,794,033.30	-212,150,571.57
39203	Авто-тээврийн хэрэгсэл	91,000,000.00	-
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,330,905,103.42	3,073,751,658.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,326,825,181.57	-1,568,950,537.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,521,924,474.39	1,422,238,128.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	-757,008,737.51	-799,602,451.39
39209	Зам, гүүрийн байгууламж	461,082,045.02	464,753,845.02
39210	Хуримтлагдсан элэгдэл	-461,082,045.02	-461,773,651.22
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	59,877,135.00	86,193,135.00
39216	Дуусаагүй барилга, байгууламж	5,197,470,299.00	5,197,470,299.00
39217	Ном	8,116,074.00	8,116,074.00
39300	Биет бус хөрөнгө	1,071,720,202.33	1,053,387,602.18
39301	Програм хангамж	218,154,418.80	218,154,418.80
39302	Хуримтлагдсан элэгдэл	-121,922,216.47	-140,254,816.62
39303	Бусад биет бус хөрөнгө	975,488,000.00	975,488,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,218,886,251.71	11,447,771,085.23
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	186,806,915.84	112,133,480.28
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	186,806,915.84	112,133,480.28
41300	Өглөг	186,806,915.84	112,133,480.28

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.01	15,096,318.30
41360	Бусад өглөг	186,806,915.83	97,037,161.98
41361	Байгууллагад төлөх өглөг	185,511,506.53	92,386,100.84
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,295,409.30	4,651,061.14
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,032,079,335.87	11,335,637,604.95
51	Засгийн газрын хувь оролцоо	11,032,079,335.87	11,335,637,604.95
